



Шинэ баригдсан битүү захад хувь нийлүүлэгчид үүсээд байгаа ноцол байдалтай холбогдуулж, Монгол улсын еронхийлогч, УИХ-ын дарга, Еронхий сайд нарт ил захидал хвргүүлжээ. Захидлыг бүрэн эхээр нь толилуулж байна.

Ховд аймгийн товд 500 гаруй худалдаа эрхлэгчийн багтаамжтай худалдааны захын битүү байр барьж ашиглалтанд оруулсан нь задгай зах дээр наймаа худалдаа эрхлэж, оворд нь даарч хорохоос эхлээд зарим бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалт нь шаардлагагад нийцэхгүй байх зэрэг олон эрсдэл учирдаг байсан бидний талархалыг хүлээсэн зүйл болсон билээ.

Онгорсон онд энэхүү битүү захыг барихаар толовлогдож байх үед аймгийн удирдлага захын худалдаа эрхлэгчидтэй удаа дараа уулзаж, уг байрыг торийн хоронгоор барих ба та нар оорсдоо тодорхой хэмжээний хоронго оруулалт хийх хэрэгтэй, шинээр баригдах битүү захын байрыг эхний жилүүдэд та ноход тортэй хамтарч, эзэмших ба хэдэн жилийн дараа та нарын өмчид шилжүүлж огно. Та нар нийлж компани байгуулах хэрэгтэй. Ингэснээр битүү зах та нарын компанийн өмч болно. Ийм замаар бид та нарыг өмчтэй болгохын тулд үүнийг хэрэгжүүлж байгаа юм гэснээр Энхтор нарын тэргүүтэй хэсэг ноход тэр компанийг байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Захын худалдаа эрхлэгч 402 хүнээс тус бүр хоёроос гурван сая тогрогийг хуримтлуулж авсан. Хувь нийлүүлэгч 402 хүн өмчтэй болохын тулд монгоо нийлүүлж компаний хувь нийлүүлэгч, эзэмшигч боллоо гэж бодож байсан ч уг компанийг оорсдийн нэрээр улсын бүртгэлд бүртгүүлсэн ноход маань луйврын шинжтэй залилан мэхлэх ажиллагаа явуулж байгааг (бүх баримт нотолгоонууд бидэнд бий) бид ажигласнаар нийт хувь нийлүүлэгчид хуралдаж, дийлэнх олонхийн саналаар уг компанийг татан буулгах, 400 –аад хувь нийлүүлэгчийн хамтарсан хоршоо байгуулах шийдвэр гаргаж “Эвийн хвч” хоршоог байгуулсан юм.

Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэхэд моноох компанийг эзэмшиж, оорийн омч болгох гэж байсан Ц.Энхтор тэргүүтэй цоон тооны ноход элдэв аргаар саад хийж байгаа бол аймгийн удирдлагын бүрэлдэхүүнд байгаа зарим ноход тэдгээр хориг саад хийгчдийг дэмжин ажиллаж эхлэв. Тодруулбал тэдгээр ноход орон нутгийн омчит компани байгуулж, шинэ баригдсан битүү захыг эзэмшилдээ авах тогтоолын тосол боловсруулан, аймгийн ИТХ-ын даргад танилцуулж буруудсан баримт байна. Хэдийгээр ИТХ-ын дарга үүнийг буруутгасан ч дээрх ноход хувь нийлүүлэгч, худалдаа эрхлэгчдийн толооллийг оролцуулаагүй ганц талыг барьсан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, торийн омчит компани байгуулах санаагаа лавшруулсаар байгаагаар барахгүй аймгийн Засаг дарга маань тэднийг оогшүүлж, “бид ОНОУГ байгуулж ажиллана. Та нарын хоршоо байгуулах нь бидэнд падгүй” хэмээж, Ховд аймгийнхаа худалдаа эрхлэгчдийг омчтэй болгох, ажиллах нохцлийг нь сайжруулах гэж барьж байгаа юм хэмээн биднээс хувь хоронго цуглуулах ажлыг зохион байгуулж байснаа мартаж, та нараас нэг тэрбум тогрог цуглуулаад авсан бол боллоо гэсэн байдлаар биднийг цааш твлхэж, гаргуунд нь хаях санаагаа цухуйлгаж эхлэв.

Торийн хоронгоор баригдсан, торийн омчид хамаарах энэ объектыг УИХ-ын шийдвэрээр орон нутгийн омчид шилжүүлээгүй байхад ийм санаа гаргаж, ийм вйлдэл хийж байгаа нь ойлгомжгүй байгаа бөгөөд хоршоо байгуулж ажиллахаар санал нэгдсэн 400 хувь нийлүүлэгчид бид уг битүү захын барилгыг торийн омчид нь байлгаж, анхны гаргаж ирсэн зорилгоор нь хамтран эзэмшиж, 400 гаруй худалдаа эрхлэгчид болон тэдний гэр бүлийг ажилтай орлоготой байлгах, дээр нь аймгийн жижиг, дунд вйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, тэдний бүтээгдэхүүнийг энд борлуулах вйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр захыг анх барьсан зорилгыг хэрэгжүүлж, үр дүнг нь үзэх чин хүсэлтэй байгаагаа илэрхийлж байна.

Үүнтэй зэрэгцэн УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Тор омчтэй байх, торийн омчийг хязгаарлах тухай торийн бодлогыг хэлэлцэхээр оруулсанд бид ихээхэн олзуурхаж байна.

Дээрх нохцол байдлыг харгалзан үзэж, Ховд аймагт баригдсан битүү захын барилгыг орон нутгийн омчид шилжүүлэлгвйгээр торийн омчид хэвээр нь байлгах замаар анхны зорилго, зорилтыг нь хэрэгжүүлбэл уг захад худалдаа вйлчилгээ эрхлэхээр хувь нийлүүлсэн 400 гаруй хувь нийлүүлэгчийн эрх ашигт нийцэж байгаа юм гэдгийг чухалчилан мэдэгдэхийг хүссэн болно.

Үнэнийг эрхэмлэсэн мэргэн зов шийдвэр гаргаж, хуйвалдаан зохиогч цоон нохдийг бус, хувь нийлүүлж эрх ашгийнхаа толоо зогсож буй дийлэнх олонх болох 400 гаруй худалдаа

вилчилгээ эрхлэгчийн эрхийг хүндэтгэнэ гэдэгт гүнээ найдаж байна. Үүнийг хүлээн авч танилцаад бидэнд албан ёсоор хариу илүүлнэ үү гээд 400 гаруй хувь нийлүүлэгч нарын үсгээ зуржээ.